



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 27

Улаан-Уул

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, 25 дугаар зүйлийн 25.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам”-ын 1.3, 3.1, 6.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь;

1. Байгууллага хооронд балансаас балансад шилжүүлэх үндсэн хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2. Тухайн байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг сумын Засаг дарга /Д.Цэдэнсодном/-д даалгасугай.

3. Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг төсөвт байгууллагын нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.


4. Тогтоолын хэрэгжилтийг 2019 оны 05 дугаар сард багтаан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлэхийг төсөвт байгууллагын даргад үүрэг болгосугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ГОНГОР

Ёсчилсон 2019 оны 05 сарын 21 ны өдөр

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 05 дугаар сарын 21-ний
өдрийн 27 дугаар тогтоолын хавсралт



БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Байгууллага	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	Тайлбар
А	1	2	3	4	5	6	7
1	ИТХ	Toyota porodox машин	2019	1	10000000	10000000	Засаг даргын Тамгын газарт
2	ЗДТГ	Пурган машин	2016	1	24500000	24500000	Соёлын төвд
3	Соёлын төв	Делика D-5	2019	1	28000000	28000000	ИТ-ийн Хуралд
Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн дүн				3	62500000	62500000	

---oOo---